

Яруу найргийн орчуулгад шүлгийн ур хийцийг нь дамжуулах асуудалд

А. Шархүү (ХИС)

Уран зохиолын орчуулга бол дуун хөрвүүлэгчээс орчуулж буй зохиолынхоо өгүүлэгдэхүүнийг үнэн зөв дамжуулахаас гадна, тухайн зохиолын ур хийц, зохиолчийн урлах арга маягийг танин мэдэж, улмаар өөр хэлээр бүрэн дамжуулахын тулд юуны өмнө орчуулга хийх хэлээ төгөлдөр сайн мэдэх, тухайн зохиолд өгүүлэх ард түмний түүх, соёлын гүн мэдлэгтэй байх гээд олон талын өргөн мэдлэг, ур ухаан, их хичээл зүтгэл шаарддаг байна. Үүний нэг л жишээ гэхэд, Азербайжаны алдарт зохиолч Самед Варгун 1943 онд уран зохиолын орчуулгын асуудлаар болсон нэг хуралдаан дээр хэлсэн үгэндээ, “Би “Евгений Онегин”-ыг орчуулах гэж 4 жил зарцуулсан. Энэ бол багадсан л хугацаа, тэгэхдээ яахав, 4 жилдээ амжсан...(13.29) Пушкиний үг хэллэг нь их цэгцтэй, тийм болохоор үг хэллэгийг нь солих, үг нэмэхэд их хайран санагдаж байсан...Гэвч Орос, Азербайжан хэлний ялгаа, шүлэглэх тогтолцооны онцлогоос үүдэн, “Евгений Онегин” найраглалд байгаа:

“Куда, Куда вы удалились.

Весны моей золотые дни

гэсэн хоёр шадын золотые дни, весны моей гэсэн хэллэгийг азербайжан хэлнээ үгчилэн орчуулах аргагүй тул золотые дни гэсэн холбоо үгийг мартагдашгүй өдрүүд, весны моей гэснийг амьдралын минь хавар гэж сольж орчуулсан. Ингэж зассан нь миний бие их томорч, сүрхийдээ бус, Пушкинийг хүндлэж биширдэгтээ сольсон юм шүү” (13.531-532) гээд энэ дашрамд хэлэхэд, “Евгений Онегиний 14 шадаас бүрдэх бадаглал, мөн холбоц хэмнэлийг нь хадгалсан” (13.530) гэж онцлон дурдсан байдаг.

Хэл, соёлын ялгаатай ард түмний хэл хоорондын орчуулга нэн түвэгтэй, тэр тусмаа яруу найргийн зохиол орчуулах бүр ч ярвигтай. Хуучин Зөвлөлт улсын шүлэг судлалын бүтээлээрээ нэрд гарсан эрдэмтэн, академич Б.Тимошевский “Хэл бүхэнд шүлгийн холбоц хэмнэл бүрдүүлэх өөр өөрийн өвөрмөц арга хэрэглүүр байдаг. Ийм учраас бас өвөрмөц шүлгийн тогтолцоотой ч байдаг. Иймд урлагийн олон төрөл зүйл дотроос яруу найрагт үндэсний хэлбэр давамгайлж байдаг” (5.68) гэж бичсэн байдаг.

Яруу найраг орчуулах хүн агуулгын тал нь болох өгүүлэгдэхүүнийг үнэн зөв гаргахаас гадна түүний хэлбэрийн тал, шүлгийн айзам хэмнэл, холбоц, ур хийцийг аль болохоор уг эхэд ойр дамжуулахыг хичээх учиртай. Энэ тухайд Орчуулагчдын Олон улсын холбооны дүрмийн I анги, 4-р зүйлд заасан нь “Ямарч орчуулга эх зохиолын утга

санаа, хэлбэрийг үнэн, яг зөв илэрхийлсэн байх ёстойн дээр, ийнхүү үнэн зөв ёсыг баримтлах нь орчуулагчийн хууль ёсны бөгөөд ёс суртахууны үүрэг болно” гэж заасан байдаг байна. Хэдийвээр тогтолцооны хувьд ялгаатай хоёр хэлний хооронд яруу найргийн бүтээл орчуулахад бэрхшээлтэй, бүр боломжгүй байж ч болох авч, аль болохоор эх зохиолд ойр орчуулахыг хичээх нь дуун хөрвүүлэгчийн үүрэг мөн.

Манай улсад бүр сонгомол эртний үеэс энэ зарчмыг чанад баримтлан ирсэн нь Дорно дахины сонгодог бүтээлээс манай өвгө дээдсийн орчуулсан бүтээл туурвилаас харагддаг. Гэтэл тэр бүр энэ зарчмыг чанад баримтладаггүйн улмаас манай нэрт орчуулагч асан Б.Ринчен одоогоос 40 гаруй жилийн өмнө яруу найргийн орчуулгын тухайд холбогдуулан: “Шүлгийн зүйлд хэлбэр олон, түүнээс хэм хэмжил нарийн баримтлан зохиосон, сүүл, толгой холбох, мөн шад дотроо авиа давтах зэргийн уран сайхны арга хэрэглэн зохиосны учрыг нь таниагүй орчуулж, утгыг нь найруулж, цаад зохиолчийн уран сайхны аргыг нь гээгдүүлдэг үзэгдэл байна”(6:117) гэж бичиж байсан билээ. Гэвч энэ талаар бид онцгой ахиц дэвшилд хүрч бүрэн чадаагүй л байна. Гэтэл монгол хэлэнд 1.2.3.4 шадаас бүрдэх шүлгийн хэлбэрүүд бий. Монгол шүлэгт шадын толгой, сүүл холбохоос гадна, шад хооронд нь ижил буюу ойролцоо сонстох авиагаар холбох, үг ба авианы сонстох хөг аялгаар илэрхийлэх утга санааг дэлгэрүүлэх гээд харь хэлнээс яруу найраг орчуулахад шаардагдах олон боломж бий. Харин тогтолцооны хувьд ялгаатай хэлнээс монгол хэлнээс орчуулахад бэрхшээл бий. Гэвч энэ талаар хуримтлуулсан туршлага бас байгаа.

Манай ахмад зохиолч Ц.Дамдинсүрэн А.С.Пушкиний “Алтан загас” зохиолын “орчуулгадаа өөрийнх нь хэлснээр үг үсгийн биш, уран чадварыг буулгах нь чухал”, ялангуяа “орос хэлээр уншихад орос хүнд ямар яруу сайхан санагддаг байна, монгол хүнд мөн тийм яруу сайхан санагддаг болгоё” гэж шийдээд бага сага үг нэмсэн боловч, ур хийц, сонстох байдлаараа уг эхэд ойр, агуулгыг бүрэн гүйцэд гаргаснаараа, монгол уншигчдын сэтгэлд хоногшсон сайн орчуулга болсон билээ. Ц.Дамдинсүрэн хожим нь орчуулсан А.С.Пушкиний “Олег Цэцэний дуулалыг орчуулсан тухай тайлбар” өгүүлэлдээ үгийн тогтвортой бат эгшиг нь үгийн эхний өргөлттэй эгшиг мөн. Энэ эгшиг бол шүлгийн гол багана, үндсэн тулгуур болно” (6.75,15.25) хэмээн үзэж, энэ үндсэн дээрээ орчуулгадаа шад бүрт буй өргөлтөт эгшгийн тоог тэгшитгэн, шүлгийн айзам хэмнэлийг орос эх зохиолд ойртуулж чадсан байна. Гэвч энэ нь орос шүлгийн тогтолцооны онцлогийг, өөрөөр хэлбэл, уран сайхны онцлогийг бүрэн дамжуулсан хэрэг биш.

Монгол шүлгийн тогтолцооны талаар судлаачдын санал зөрөөтэй байдаг. Тийм ч учраас зарим судлаач монгол шүлгийн гол зарчим бол шүлгийн мөрийн толгой холбох явдал бөгөөд тусгайлан журамлагдсан шүлгийн тогтолцоо алга байна гэж үзэж байв.

Оросын нэрд гарсан монголч эрдэмтэн академич монгол хэлний үгийн өргөлт тогтмол нэгдүгээр үе дээрээ оногддог гэж үздэг асан Б.Я.Владимирцов голцуухан аман

зохиолын материал, ардын дууг судлаад монгол шүлэг бол мөр бүрд тэнцүү тоотой өргөлтөт эгшиг оногдох зарчимд тулгуурлагддаг бөгөөд нэг мөрдөө 3,4,5,7 өргөлттэй үе бүхий тоник шүлэг (1.55) юм гэж үзэж байжээ. Тэр ч байтугай монгол яруу найргийн зохиол дотор үе өргөлтийн шүлэг ч дайралдаж байлаа (1.102) гэж тэмдэглэсэн нь бий.

Манай нэрт орчуулагч, яруу найрагч Ч.Чимид монгол шүлгийн бүтцийг судлаад монголд хорей (бүжил өлмий) хэмжээтэй шүлэг байдаг боловч монгол шүлгийн үндсэн зарчим нь мөр бүрд орох өргөлтөт үеийг жигдлэх явдал мөн тул монгол шүлэг бол өргөлтийн шүлэг (9.96) юм гэж Б.Я.Владимирцовынхтой үндсэндээ тохирох санал дэвшүүлж байсан боловч, монгол хэлээр дэлхийн аль ч улс орны шүлгийн тогтолцоонд дүйх шүлэг бичих боломжтой (9.99) гэж үзэж байв. Монгол шүлгийн хэмнэл зүйн үндсэн нэгж нь үг мөн гэсэн ерөнхий дүгнэлтэд хүргэх энэ саналыг уран зохиол судлагч Ш.Гаадамба (3.145), Н.Жамбалсүрэн (11), Д.Цэнд (10.119), нар хүлээн зөвшөөрцгөөсөн байна. Гэвч Б.Я.Владимирцовоос ялгаатай нь гэвэл саяхи судлаачид монгол хэлний өргөлт тогтмол I үедээ байдаг л бол онолын хувьд зөвхөн хорей, дактиль гэж хоёрхон л өөр хэмжээтэй шүлэг бичих боломжтой тул, яавч энэ нь монгол шүлгийн тогтолцоог тодорхойлохгүй гэж үзэж байв. Шүлэг судлаач академич Д.Цэрэнсодном монгол шүлгийн тухай шүүмжлэн хэлэлцэхэд зориулж бичсэн өгүүлэлдээ их төлөв ардын аман зохиол, мөн эртний уран зохиолын бүтээлүүдийг туурвилзүйн талаас нягтлан судлаад монгол шүлэг бол угтаа нэг мөрд орох үгийн үеийн тоог тэгшитгэн бичдэг үеийн шүлэг юм гэсэн арай өөр санал дэвшүүлсэн (10:87-103) нь бий.

Хуучин Зөвлөлт улсын монголч эрдэмтэн Л.К.Герасимович монгол шүлгийн тогтолцооны онцлогийг туршилт авиазүйн аргаар судлаад, шүлгийн шадын урт, богинын зөрөөг уншихдаа сунгах, эсвэл, агшаан дуудаж цагаар тэнцүүлэх зарчим бол монгол шүлгийн тогтолцооны айзам хэмнэлийг тогтоох хамгийн гол үзүүлэлт мөн хэмээн үзсэн байна. (2.63-65).

Энэ мэтээр монгол шүлгийг судлаачид өөр өөр саналтай байгаа нь нэг талаас монгол хэлний шүлгийн тогтолцоо уян хатан, олон янз гэдгийн баримт ч гэж болохоор юм.

Академич Б.Ринчен монгол хэлшинжлэл, монголын утга соёлыг олон жил судласан баримт мэдээнд тулгуурлан, монгол яруу найргийн уламжлалд үеийн шүлэг, урт // богино, өргөлтөт // өргөлтгүй үеийн тодорхой эрэмбээр сэлгэх шүлэг, мөн тэргүүн үедээ өргөлттэй хэл тул Европ зүгийн шүлгийн бүх хэмжээ бий гэж үзсэн байна (14:84-85). Үнэхээр бидний ажиглалт судалгаанаас үзвэл монгол хэлээр үеийн ба өргөлтийн шүлэг, үе өргөлтийн шүлэг, түүний дотор тодорхой журмалсан холбоц хэмнэлтэй сонет, рондо, одоо манайд танил болоод байгаа японы танка, хайку, гэндайши зэргийн шүлгийг ч айзам хэмнэл, хэмжээг хадгалан орчуулах боломж байна.

Ишлэл авсан ном

1. Я. Владимирцов. Сравнительная грамматика монгольского языка и халхасского наречия. Л. 1929
2. Л.К. Герасимович. Монгольское стихосложение. Л. 1975
3. М. Гаадамба. Утга зохиолын онолын товч. УБ. 1958
4. К.И. Чуковский. Высокое искусство. М. 1964
5. Б. Томашевский. Стих и язык. М-Л. 1958
6. Орчуулах эрдэм. УБ. 1972
7. Орчуулах эрдэм. УБ. 1979
8. Орчуулах эрдэм. УБ. 1988
9. Цог. (Сэтгүүл) 1950. №2
10. Цог. (Сэтгүүл) 1964. №5
11. Утга зохиол сонин. 1956 №8
12. Утга зохиол сонин. 1984 №13
13. Художественный перевод Взаимодействие и взаимообогащение литератур. Ереван. 1973
14. Б. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. УБ. 1964
15. Ц. Дамдинсүрэн. Монгол хэл бичгийн тухай. УБ. 1967